



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймаг Сэврэй сумын “Нийтлэг үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2022/30/-НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас:
www.umnugovi@audit.gov.mn

Даланзадгад сум

2022 он

ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа

Утас: 70533539 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК

Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



1.Аудитын санал дүгнэлт

СЭВРЭЙ СУМЫН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ЗАХИРАЛ
Д.ЭНХМАА ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөговь аймаг Сэврэй сумын “Нийтлэг үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тус байгууллагын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай. Өмнөговь аймгийн Сэврэй сумын ИТХТ-ийн 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан дүрмийн 9.1-т: “Сэврэй сумын Нийтлэг үйлчилгээний газрын удирдах буюу эрх барих дээд байгууллага нь Сэврэй сумын ИТХ болон Сэврэй сумын Нийтлэг үйлчилгээний газрын Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал болно” гэж заасан байна.

Нүдэн булаг амралт сувилалыг тохижуулах, халуун усыг халаалттай болгох зорилгоор сум хөгжүүлэх сангаас 13.0 сая төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатайгаар авчээ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 127.7 сая төгрөгийн хөрөнгийг байгууллага бүрэн ашиглаж байгаа нь санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангаж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд



хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Өмнөговь аймаг Сэврэй сумын 2021 оны бизнес төлөвлөгөөг боловсруулж, Сумын засаг даргын орлогч Р.Чинбат баталсан ба төлөвлөгөөнд 6 арга хэмжээг төлөвлөснөөс, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 58.2 хувийн хэрэгжилттэй байна.

Энэ нь 2021 оны 1-5 сард хог хаягдлыг зөөвөрлөсөн ба 6 сараас эхлэн хог хаягдлыг “Дэмд Од” ОНӨААТҮГ-т шилжүүлсэнээр хог тээвэр, халуун усны орлогогүй болсон, 2020 оноос эхлэн үргэлжилж буй цар тахалтай холбоотойгоор 2021 оны 03 дугаар сараас эхлэн зочид буудлыг улаан бүсийн эмнэлэг болгон ашигласан, сумын төв бохирын нэгдсэн системд холбогдсоноор бохир зөөврийн орлогогүй болсон, Өмнөговь аймаг стратегийн бүс гэж хөл хорио нэлээд тогтоосоны улмаас амралт сувилалын газрын үйл ажиллагаа 2020 оны 03 дугаар сараас 2021 оны 05 дугаар сар хүртэл зогссон зэрэгтэй холбоотой байна.

Бусад асуудал

Дэлхийн нийтээр ковид-19 цар тахалтай холбоотойгоор байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал хумигдсан байна.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
Үзүүлэлт		2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	22.7	15.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	429.5	112.1
	Нийт хөрөнгийн дүн	452.2	127.7
	Нийт өр төлбөрийн дүн	310.9	10.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	141.3	117.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	452.2	127.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	67.9	38.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	95.9	62.1
	Үйл ажиллагааны үр дүн	(28.0)	(23.7)
	Үйл ажиллагааны бус үр дүн	20.7	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(7.3)	
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	141.4	141.4
	Тайлант оны үр дүн	(7.3)	(23.7)
	Эцсийн үлдэгдэл	134.1	117.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	42.4	29.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	38.6	34.3
	Үйл ажиллагааны ЦМГ	3.8	(5.0)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2.9	6.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6.7	1.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		
	Урсгал зардал		
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих		
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэврэй сумын “Нийтлэг үйлчилгээний газар” ОНӨААТҮГ нь Сэврэй сумын ИТХТ-ын 18 дугаар тогтоолыг үндэслэн 2014 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах,



өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан ба энэ хүрээнд 4 арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. Үүнд:

- ✚ Иргэдийн боловсролыг дэмжих, сургалтын орчин бүрдүүлэх;
- ✚ Аялал жуулчлалыг дэмжих, үйлчлэх;
- ✚ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх экологийн боловсролыг дээшлүүлэх;
- ✚ Хээрийн болон сумын золбин нохой устгах, сумын иргэдийг түр болон байнгын ажлын байраар хангах ая тухтай амьдрах боломжоор ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу 2021 онд 4 орон тоотойгоор баталсан ба чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 1-ээр бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан ТҮ-ийн 12-1 тогтоосон байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай. Өмнөговь аймгийн Сэврэй сумын ИТХТ-ийн 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан дүрмийн 9.1-т: “Сэврэй сумын Нийтлэг үйлчилгээний газрын удирдах буюу эрх барих дээд байгууллага нь Сэврэй сумын ИТХ болон Сэврэй сумын Нийтлэг үйлчилгээний газрын Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал болно” гэж заасан байна.

Нүдэн булаг амралт сувилалыг тохижуулах, халуун усыг халаалттай болгох зорилгоор сум хөгжүүлэх сангаас 13.0 сая төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатайгаар авчээ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 127.7 сая төгрөгийн хөрөнгийг байгууллага бүрэн ашиглаж байгаа нь санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангаж байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.



Өмнөговь аймаг Сэврэй сумын 2021 оны бизнес төлөвлөгөөг боловсруулж, Сумын засаг даргын орлогч Р.Чинбат баталсан ба төлөвлөгөөнд 6 арга хэмжээг төлөвлөснөөс, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 58.2 хувийн хэрэгжилттэй байна.

Энэ нь 2021 оны 1-5 сард хог хаягдлыг зөөвөрлөсөн ба 6 сараас эхлэн хог хаягдлыг “Дэмд Од” ОНӨААТҮГ-т шилжүүлсэнээр хог тээвэр, халуун усны орлогогүй болсон, 2020 оноос эхлэн үргэлжилж буй цар тахалтай холбоотойгоор 2021 оны 03 дугаар сараас эхлэн зочид буудлыг улаан бүсийн эмнэлэг болгон ашигласан, сумын төв бохирын нэгдсэн системд холбогдсоноор бохир зөөврийн орлогогүй болсон, Өмнөговь аймаг стратегийн бүс гэж хөл хорио нэлээд тогтоосоны улмаас амралт сувилалын газрын үйл ажиллагаа 2020 оны 03 дугаар сараас 2021 оны 05 дугаар сар хүртэл зогссон зэрэгтэй холбоотой байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 344.6 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс 333.5 сая төгрөгийн 3 алдаанд завсрын аудитын явцад залруулга хийж, 1 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 11.1 сая төгрөгийн 3 зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 0.6 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 2.3 сая төгрөгийн түвшинээс 1.7 сая төгрөгөөр бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай 333.5 сая төгрөгийн залруулга завсрын аудитаар бүрэн хийгдсэн.

8.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

8.3 Албан шаардлага

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 142 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь байршуулж, сар бүр оруулахаас 3 мэдээлэл, бүтэн жилээр оруулахаас 2 мэдээлэл, нийт 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй, дахин давтагдсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т: “хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1,



6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх” гэж заасантай нийцэхгүй, эрх үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлэн зөрчлийг давтан гаргахгүй байж, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өглөг данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангаар 0.4 сая төгрөгийн авлагыг, 10.0 сая төгрөгийн өглөгийг тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулаагүй байна.

1.2. Эрсдэл:

Авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулж баримтжуулаагүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д: "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөж ажиллах

2. Цахим төлбөрийн системтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд цахим төлбөрийн системд 0.6 сая төгрөгийн баримт шивэгдээгүй, анхан шатны баримт гаргуулан аваагүй, баримтын бүрдэлтэнд хяналт тавьж залруулаагүй байна.

2.2. Эрсдэл:

Цахим төлбөрийн системийн хяналт хангалтгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д: "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг мөрдөж ажиллах

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" гэж заасны дагуу 2021 онд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулаагүй, хяналт шалгалтын баг зохион байгуулаагүй байна.

3.2. Эрсдэл:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын заалтыг хэрэгжүүлээгүй байх.

3.3. Өгсөн зөвлөмж:



МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж, байгууллагын дотоод хяналт шалгалтын баг ажиллуулах

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨААҮГ	1	1			1			
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ									

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
1	ТШЗ											
2	ОНӨААТҮГ	7	343.9	3	333.4			1	0.0	2	10.5	
3	ЗГТС											
4	ТТЗ											
5	ТЕЗ											
НИЙТ		7	343.9	3	333.4			1	0.0	2	10.5	